


ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Үнэт цаасны зах зээлийн тойм

1991 оноос улсын үйлдвэрүүдийг хувьчилж эхлэхэд Монголын хөрөнгийн бирж /МХБ/-д бүртгэлтэй нийт компанийн тоо 475 байсан ба зах зээлийн үнэлгээ нь 2000 онд 40.5 тэрбум төгрөг байсан бол 2015 оны эцсийн байдлаар нийт хувьцаат компанийн тоо 235 болж, зах зээлийн үнэлгээ 1.3 их наяд төгрөгт хүрсэн байна. МХБ-д бүртгэлтэй компанийн тоо болон нийт зах зээлийн үнэлгээ хэрхэн өөрчлөгдсөнийг дорх графикаар үзүүллээ.




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо
(Тухайн жилийн зах зээлийн үнэлгээг тухайн оны эцсийн хаалтын ханиаар тооцоолсон болно)

Дээрх графикаас харахад зах зээлийн үнэлгээ 2011 онд хамгийн дээд дүнд хүрч, түүнээс хойш аажмаар буурсан ч 2009 оноос өмнөх үзүүлэлтүүдээс өссөн байна. Энэхүү урт хугацааны өөрчлөлтөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзэж байна. Үүнд: Энэ хугацаанд хувьчлалын үр дүнд бий болсон бүртгэлтэй компанийн тоо жил бүр буурч, 2015 онд нийт бүртгэлтэй компанийн тоо 235 болж, 2011 оныхоос 97 компаниар бага болсон нь зах зээлийн үнэлгээний хэмжээ буурахад тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байж болно. Нөгөөтэйгүүр, 2005 оноос хөрөнгийн зах зээл сонгодог утгаараа хөгжиж эхлэн, дотоодын аж ахуйн нэгжүүд үнэт цаасаа олон нийтэд санал болгож, санхүүжилт татаж эхэлснээр 2015



2015 оны арилжааны бүтэц




оныг дуустал шинээр 16 компани МХБ-д бүртгүүлсэн, түүнчлэн ихэнх бүртгэлтэй компанийн үйл ажиллагаа өргөжиж, хувьцааны ханш өссөнтэй холбоотой зах зээлийн нийт үнэлгээ 2005 онтой харьцуулахад огцом өсөлттэй хэвээр байна. Мөн сүүлийн 7 жилийн туршид МХБ-ээр хийгдсэн үнэт цаасны нийт

арилжааны хэмжээг дээр графикаар харууллаа. Үнэт цаасны арилжаанд хувьцаа, Засгийн газрын үнэт цаас /бонд-ЗГҮЦ/ болон компанийн бонд багтаж байна. Хувьцааны арилжаа 2012 онд хамгийн дээд цэгт хүрч, түүнээс хойш буурсаар 2015 онд 2009 оны түвшинд очсон нь дотоод гадаадын эдийн засгийн нөхцөл байдал муудаж, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан, хөрөнгө оруулагчдын худалдан авах чадвар буурсан зэргээс хамааралтай юм. Харин МХБ-ээр явуулсан ЗГҮЦ-ны арилжаа 2012 оноос зогссоны дараа 2014 оны сүүлээс дахин эхэлж, 2015 онд хамгийн өндөр дүнтэй 516 тэрбум төгрөгт хүрсэн нь 2015 оны нийт арилжааны 94.3 хувийг эзэлсэн байна.

ТОП-20 индексийн үзүүлэлт

Хөрөнгийн зах зээлийн хэмжээ болон өсөлт, бууралтыг ТОП-20 болон MSE ALL индексээр төлөөлөн үзүүлдэг ба ТОП-20 индекс нь тухайн хагас жилд хамгийн идэвхтэй арилжигдаж буй хамгийн өндөр зах зээлийн үнэлгээ бүхий 20 компанийн хувьцаанаас бүрддэг. ТОП-20 багцыг үүсгэж буй 20 компанийн зах зээлийн үнэлгээ нь нийт үнэт цаасны зах зээлийн үнэлгээний 60-85 хувийг бүрдүүлж байгаа тул ТОП-20 индексийг графикаар харуулбал нийт зах зээлийн үнэлгээний графиктай адил дүр зургийг харуулж байна. 2015 онд ТОП-20 индекс 11,700 нэгж хүрч буурсан нь 2010 оны хэмжээнд хүрсэн байна.



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ТОП-20 индекс нь хагас жилд нэг удаа шинэчлэгддэг бөгөөд 2016 оны эхээр шинэчлэгдсэн багцад орсон компаниудыг дараах хүснэгтэд харууллаа. Үүнд өмнөх багцад байсан Ремикон ХК, Монголиа девелопмент ресорсес ХК, Монголын цахилгаан холбоо ХК, Материал импекс ХК хасагдаж, Хай би ойл ХК, Ариг гал ХК, Э-Транс ложистикс ХК, Мерекс ХК-ийн хувьцаа нэмэгдсэн байна.

2016 оны 1-р сарын байдлаар ТОП-20 индексийн багцад багтсан 20 компани:

№	Сим-бол	Компанийн нэр	Салбар	№	Сим-бол	Компанийн нэр	Салбар
1	BNG	Баянгол зочид буудал ХК	Худалдаа үйлчилгээ	11	ВУК	УБ-БУК ХК	Барилгын тусгай үйл ажиллагаа
2	ТСК	Талх чихэр ХК	Хүнс	12	TTL	Таван толгой ХК	Уул уурхай
3	NEH	Дархан нэхий ХК	Үйлдвэрлэл	13	SHV	Шивээ овоо ХК	Уул уурхай
4	APU	АПУ ХК	Аж үйлдвэр	14	UID	Улсын их дэлгүүр ХК	Худалдаа үйлчилгээ
5	HBO	Хай би ойл ХК	Уул уурхай	15	MMX	Махимпекс ХК	Худалдаа үйлчилгээ
6	EER	Ариг гал ХК	Аж үйлдвэр	16	JTB	Женко тур бюро ХК	Худалдаа үйлчилгээ
7	SHG	Шарын гол ХК	Уул уурхай	17	BDS	Би ди сек ХК	Брокер, Дилерийн үйл ажиллагаа
8	HRM	Гермес центр ХК	Үйлдвэрлэл	18	ETR	Э-Транс ложистикс ХК	Барилга тээвэр
9	GOV	Говь ХК	Ноос ноолууран эдлэл	19	MRX	Мерекс ХК	Аж үйлдвэр
10	BAN	Багануур ХК	Уул уурхай	20	HGN	Хөх ган ХК	Аж үйлдвэр

2016 оны 1-р сарын үнэт цаасны арилжаа

2016 оны эхний сард МХБ-ээр нийт 466.2 сая төгрөгийн үнийн дүнтэй арилжаа хийгдэж, 60 компанийн 625,094 ширхэг хувьцаа арилжигдсан байна. Энэ нь өмнөх оны мөн үед хийгдсэн арилжааны дүнтэй харьцуулахад 2 дахин буурсан үзүүлэлт байсан бол 2015 оны 12-р сарын 1.55 тэрбум төгрөгийн

арилжааны дүнтэй харьцуулахад 3.3 дахин буурсан үзүүлэлт байв. Энэ сард зах зээлийн үнэлгээний дүн 1.46 их наяд төгрөг байсан ба өмнөх оны мөн үеийнхээс 5.7 хувиар өндөр байлаа. Засгийн газрын үнэт цаасны хувьд 1-р сард 4 удаагийн арилжаагаар нийт 11.8 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжигдсан байна. ЗГҮЦ-ны арилжааны өдөр Мягмар гараг байсныг 2016 оны 1-р сард Даваа гараг болгож, Лхагва-Баасан гарагуудад захиалга авлаа. 1-р сард арилжигдсан ЗГҮЦ-ны мэдээллийг дорх хүснэгтээс харна уу.


Арилжигдсан хугацаа	ЗГҮЦ-ны хугацаа	Хүүгийн хэмжээ, %	Тоо ширхэг	Нэгжийн үнэ, төг	Үнийн дүн, сая төг	Дуусах хугацаа
2016/1/11	28	14.93	8,315	92,576	831.5	2016/7/25
2016/1/11	156	15.75	5	100,000	0.5	2019/1/07
2016/1/18	52	15.20	10,139	100,000	1,013.9	2017/1/16
2016/1/25	12	13.56	100,000	96,974	10,000	2016/4/18
Нийт			118,459		11,846	

МХБ-д шинээр бүртгэгдсэн хувьцаа: МИК, МNP

2015 оны эцэс болон 2016 оны эхээр МХБ-д төрийн өмчит 2 компани шинээр бүртгэгдсэн. Монголын ипотекийн корпораци холдинг ХК, Монгол шуудан ХК анх удаа олон нийтэд хувьцааны тодорхой хувийг санал болгон, 37.28 тэрбум, 6.26 тэрбум төгрөгийг тус тус амжилттай татлаа.

Монголын ипотекийн корпораци Холдинг ХК (МИК) нь 2015 оны 12-р сарын 24-ний өдөр олон нийтээс 15 хувь буюу 37.28 тэрбум төгрөг татсан. 2-р сарын 15-ны өдрийн байдлаар хувьцааны ханш нь анхдагч зах зээлд санал болгосон ханшаас /12,000 төгрөг/ 2.08 хувь өсч, 12,250 төгрөгт хүрсэн ба тус компанийн зах зээлийн үнэлгээ 253.7 тэрбум төгрөг болсон байна.


МИК нь энэхүү татсан хөрөнгөөр орон сууцны зээлийн багцыг буцаах нөхцөлтэйгээр худалдан авахад зарцуулах буюу өөрийн үндсэн ажиллагааг санхүүжүүлэх юм.



Хувьцаа эзэмшигчид	Хувь
Улаанбаатар банк	28.66%
Худалдаа хөгжлийн банк	25.65%
Хөгжлийн банк	14.88%
Капитал банк	8.12%
Ти Ди Би Капитал ҮЦК	7.53%
Бусад 79	30,81

Монгол шуудан ХК (MNP) нь 2016 оны 1-р сарын 8-ны өдөр олон нийтээс 6.26 тэрбум төгрөгийн хөрөнгийг татсан ба 2016 оны 2-р сарын 15-ны өдрийн байдлаар хувьцааны ханш нь нийтэд санал болгосон 185 төгрөгөөс 310 төгрөгт хүрсэн нь 67.6 хувийн өсөлтийг үзүүлж, зах зээлийн үнэлгээ нь 30.9 тэрбум төгрөг болсон байна. Тус хувьцааны ханш хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсний дараах 4 өдрийн турш тасралтгүй өссөөр 322 төгрөгт хүрсэн байна.

Монгол шуудан ХК нь олон нийтээс татсан хөрөнгөөрөө Замын-Үүдийн чөлөөт бүсэд логистикийн төвийг барьж ашиглалтанд оруулах ба шаардлагатай тоног төхөөрөмж, машин механизм авахад зарцуулна.



Хувьцаа эзэмшигчид	Хувь
Төрийн эзэмшил	66%
Ард санхүүгийн нэгдэл ХК	17.4%
Хишиг арвин индастриал ХХК	5.2%
Түвшин	6.4%
Бусад 355	5%

Эх сурвалж: ҮЦТТХТ

2015 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

Монгол Улсын 2015 оны эдийн засгийн байдал

2015 оны эцсийн байдлаар манай улсын ДНБ-ий хэмжээ 15.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оныхоос 2.3 хувь өссөн байна. Үүнд хөдөө аж ахуйн /ХАА/ салбар 10.7 хувь, уул уурхайн салбар 13 хувиар тус тус өсчээ. 2015 оны эцсийн байдлаар инфляци 1.9 хувьтай гарч, өмнөх оны 11 хувиас огцом буурсан байна. Чанаргүй зээл 825 тэрбум буюу нийт зээлийн 7 хувийг эзэлжээ. Харин Монгол банкны валютын нөөцийн хэмжээ 1.4 тэрбум ам.долларт хүрсэн байна. Монгол Улсын экспорт болон импортын мэдээллээс харахад 2015 оны эцэст экспортын эрдэс бүтээгдэхүүний хэмжээ буурсантай холбоотойгоор экспортын орлого буурчээ.




Эх үүсвэр. Үндэсний статистикийн хороо



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2015 оны нийт импортын бараануудаас уул уурхайн тоног төхөөрөмж болон түүний сэлбэг хэрэгслийн импортын хэмжээ эрс буусан бол импортын шатахуун, түлшний хэмжээ өсч, үнийн дүн буурсан нь өмнөх оны импортын үзүүлэлтээс буурах хүчин зүйл болжээ. Харин импортын эрчим хүчний хэмжээ 2014 болон 2015 онд үнийн дүнгээс төдийлөн өөрчлөгдөөгүй байна.




Нийт экспортод эрдэс бүтээгдэхүүний экспортын хэмжээ сүүлийн 3 жилийн хугацаанд 79-83 хувийг эзэлж байна. Харин хүнсний бүтээгдэхүүн нийт импортод хамгийн өндөр хувийг эзэлж байгаа ба сүүлийн 3 жилийн туршид хүнсний импортын хэмжээ буурсан боловч нийт импортын хэмжээ буурсантай холбоотойгоор түүнд эзлэх хувь өсчээ.

Эх сурвалж: УСХ

Монгол Улсын 2016 оны экспортын төлөв

Монгол Улсын нийт экспортын ихэнх хувийг бүрдүүлдэг эрдэс бүтээгдэхүүний экспортын орлогыг төсөөлөхөд эрдэс бүтээгдэхүүний үнийн өөрчлөлт болон ирээдүйн эрэлтийн хэмжээ чухал юм. Тиймээс манай экспортын бүтээгдэхүүний гол хэрэглэгч болох БНХАУ-ын ирэх 5 жилийн төлөвлөгөөнөөс үндсэн экспортын эрдэс бүтээгдэхүүн болох зэс, нүүрс, төмрийн хүдэр болон газрын тосны эрэлтийг тодорхойлох боломжтой. Зарим эрдэс бүтээгдэхүүний экспортын үнийн дүнг дор графикаар харуулж, тус бүрээр мэдээллийг тоймлон хүргэж байна.

Экспортлогдсон зарим эрдсүүд, үнийн дүнгээр (тэрбум.ам.дол)




Зэсийн баяжмал: Монгол Улсын зэсийн баяжмалын үйлдвэрлэл 2013 оноос хойш өссөөр 2015 оны эцсийн байдлаар 1.5 сая.тн үйлдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 7 хувь өссөн байна. Ийнхүү өссөн шалтгаан нь Оюу Толгой ХХК нь 2013 оны 7-р сард анх удаа зэсийн баяжмал экспортлож, зэсийн үйлдвэрлэл эхэлсэнтэй холбоотойгоор зэсийн экспортын хэмжээ сүүлийн хоёр жилд өссөн дүнтэй байна. Оюу Толгой ХХК 2015 онд нийт 670-745 мян.тн зэсийн баяжмал /цэвэр зэс 175-195 мян.тн/ үйлдвэрлэхээр төлөвлөж байсан бол 2015 оны эцсийн байдлаар 788.5 мян.тн зэсийн баяжмал буюу 202.2 мян.тн цэвэр зэс үйлдвэрлэн төлөвлөгөөгөө давуулсан байна. Харин 2016 онд 2015 оны төлөвлөгөөний адил 670-745 мян.тн зэсийн баяжмал /175-195 мян.тн цэвэр зэс/ үйлдвэрлэхээр төлөвлөсөн байна.



Оюу Толгой ХХК нь 2015 онд улсад нийт 315 сая ам.долларын татварын орлого оруулсан нь төсвийн орлогын 10.5 хувийг бүрдүүлжээ. 2014 онд энэ үзүүлэлт 7.4 хувь байсан бол 2015 онд ийнхүү өссөн байна. Харин зэсийн үнэ 2015 онд өнгөрсөн оныхоос 17.3 хувиар буурч, 1,543 ам.доллар/тн болсон ба 2016 онд зэсийн үнийн бууралт үргэлжилбэл экспортын орлого энэ жилийнхээс ихгүй байх хүлээлттэй байна. Үйлдвэрлэлийн бүс ихтэй БНХАУ-ын эдийн засаг удааширсантай холбогдон, үйлдвэрлэлийн түүхий эд болох зэсийн ханш ойрын 2 жилийн хугацаанд 2015 оны ханшаас өсөхгүй байх хүлээлттэй байна.

Экспортлогдсон нүүрсний хэмжээ, үнэ




Нүүрс: Сүүлийн жилүүдэд дэлхийн хэмжээнд нүүрсний нийлүүлэлт өссөнтэй холбоотой нүүрсний үнэ буурсаар байна. Монгол Улсын нүүрсний экспортын хэмжээ 2009 оноос өсч эхэлсэн ч 2011 оноос хойш жил бүр буурчээ. Монгол Улс 2015 онд нийт 14.5 сая тонн нүүрс экспортлосон нь өмнөх оныхоос 25.8 хувь буурсан. Нүүрсний үнэ өмнөх оныхоос 11.7 хувь буурч, 1 тонн нүүрсний үнэ дунджаар 38.4 ам.доллар болжээ. Монгол Улсын нүүрсний нийт экспортын 99.8 хувь Хятад руу гардаг тул нүүрсний экспортын ирээдүйн байдлыг таамаглах үүднээс БНХАУ-ын нүүрсний хэрэглээг тоймлон хүргэе.

Дэлхийн нүүрсний хэрэглээний талаас илүү хувийг буюу 2015 оны байдлаар нийт 3.5 тэрбум тонн нүүрсийг БНХАУ дангаараа хэрэглэсэн ба гангийн үйлдвэрлэлдээ их хэмжээний нүүрс ашиглагдаг байна. Гэвч хятадууд ирэх 2020 он хүртэл нүүрсний хэрэглээний өсөлтөө тогтоон барих бодлого хэрэгжүүлэхээр болсон нь сүүлийн үеийн тулгамдсан асуудал болох агаарын бохирдлыг бууруулах зорилготой ажээ.

Олон улсын Эрчим хүчний агентлагийн зүгээс гаргасан тайланд “2020 он гэхэд нүүрс нь үнийн хувьд хямд учир эрчим хүчний чухал эх үүсвэр хэвээр байх болно. Өнгөрсөн жилүүдэд аж үйлдвэрлэл ихтэй байсан тул Хятадын нүүрсний эрэлтийн хэмжээ нь хамгийн дээд цэгтээ хүрсэн байх магадлалтай юм” гэжээ. Үүнээс харахад ойрын ирээдүйд БНХАУ-ын хувьд нүүрсийг хэрэглэсээр байх хэдий ч эрэлтийн хэмжээ төдийлөн өсөхгүй гэж үзэж байна. Түүнчлэн, Хятадын нүүрсний хэрэглээний бууралт болон Хятад руу нүүрс экспортлодог бусад орнуудын хүчин чадал ихсэж байгаа нь Монгол Улсын нүүрсний экспортод сөргөөр нөлөөлөх хандлагатай байна. Манай улсын нүүрсний экспортын орлого нүүрсний үнэ болон хэмжээнээс аль алианаас нь шалтгаалан буурч байгаа тул гадагш экспортлож буй нүүрсний чанарыг сайжруулах, эсвэл нүүрсээр байгальд ээлтэй эрчим хүчний бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь оновчтой болох юм.

Төмрийн хүдэр: Монгол Улс 2015 оны эцсийн байдлаар нийт 5,065.1 мянган тонн төмрийн хүдэр экспортлож, 227.4 сая ам долларын орлого олжээ. Энэхүү орлого нь 2014 оныхтой харьцуулахад 49.1 хувиар буурсан ба нийт экспортын орлогын 4.9 хувийг бүрдүүлсэн байна. Манай улсын нийт төмрийн хүдрийн нөөцийн хэмжээг 660 сая тонн гэж тогтоосон байдаг. Харин БНХАУ 23 тэрбум тонн нөөцтэй ба төмрийн хүдрийн томоохон үйлдвэрлэгчийн зэрэгцээ томоохон хэрэглэгч юм. 2014 оны байдлаар БНХАУ дэлхийн нийт 1,665 сая тонн ган үйлдвэрлэлийн 49.4 хувийг үйлдвэрлэсэн бол нийт 1,537 сая тонн гангийн хэрэглээний 46.2 хувийг дангаар эзэлжээ. Төмрийн хүдрийг ган болгоход өндөр илчтэй коксжсон нүүрсийг хэрэглэдэг ба дэлхийн гангийн үйлдвэрлэлийн 70 хувийг коксжсон нүүрсээр үйлдвэрлэдэг байна.




Өнөөдөр дэлхийн гангийн 50 орчим хувь нь барилга байшингийн салбарт ашиглагддаг ба барилгын салбарын өсөлтөөс хамаарч ган болон төмрийн хүдрийн үнэ тогтдог байна. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд БНХАУ-ын барилгын салбарын өсөлт жилд дунджаар 16.2 хувь байсан. Хятадын барилгын салбарын хувьд 2013 онд өсөлтийн дээд цэгт хүрсэн ба урт хугацаанд буюу 2030 он хүртэл салбарын өсөлт 4.8-5.2 хувьтай байна гэж Хятадын зарим шинжээчид үзсэн байна. 2015 оны эхний арван сарын

байдлаар Хятадын гангийн нийлүүлэлт нь эрэлтээсээ давсантай холбогдон гангийн үнэ буурсаар байна. Энэ нь Хятад руу төмрийн хүдэр экспортодог Монгол Улсын хувьд таагүй мэдээ болж байгаа юм. Үүнтэй холбоотойгоор манай улс төмрийн хүдрийг дотооддоо боловсруулан экспортлох мөн импортыг орлох үйлдвэрлэл эрхлэх нь илүү үр дүнтэй байхаар харагдаж байна.

Газрын тос: 2015 онд Монгол Улс нийт 387 сая ам.долларын үнийн дүн бүхий 8.1 сая тонн боловсруулаагүй газрын тос экспорлосон байна. Энэ нь нийт экспортын 8.3 хувийг эзэлсэн ба 2014 оны экспортын дүнгээс 39.1 хувь буурсан байна. 2014 оны эцсийн байдлаар тогтоогоод байгаа Монгол Улсын газрын тосны баталгаат нөөц 332.6 сая тонн бөгөөд газрын тосны олборлолт жил ирэх бүр нэмэгдсээр байна. Жилд 2015 онтой адил 8.1 сая тонныг олборлохоор тооцвол Монгол Улс 40 жилийн газрын тосны батлагдсан нөөцтэй харагдаж байна. Монгол Улс газрын тосоо экспортлож байгаа тохиолдолд үнэ олон улсын жишгээр тогтох ба дэлхийн газрын тосны үнэ 2014 онд 92 ам.доллар/баррель байсан бол 2016 он гарсаар 31.45 ам.доллар/баррель болтлоо унасан байна. Манай улс газрын тосны хувьд жижиг олборлогч тул дэлхийн зах зээлийн үнээс хамаарч газрын тосны экспортын орлого 2016 онд улам буурах хандлагатай байна.



Монгол Улс импортоор дизель түлш, АИ-92,95, А-80 болон бусад нефтийн бүтээгдэхүүнийг авч ашигладаг ба 2015 онд импортод нийт 1,155 сая ам.доллар зарцуулжээ. Хэрэв Монгол Улс дотооддоо түлш үйлвэрлэдэг болбол гадагш урсаж буй энэхүү хөрөнгийг багасгах боломжтой юм.



Цайр: Монгол Улсын батлагдсан цайрын нөөц 5.9 сая тонн ба цайрын экспортын хэмжээ 2015 он 84.1 мянган тонн байгаа нь энэ хэмжээгээр олборлоход 70 жилийн нөөцтэй байна. Цайрын баяжмалын үнэ сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна. Цайр нь эм бэлдмэл, металлын бүрмэл, батерей гэх мэт аж үйлдвэрлэлийн нэмэлт бүтээгдэхүүн хэлбэрээр ашиглагддаг.



Алт: Монгол Улс нийт 1,328 тонн алтны нөөцтэй гэсэн мэдээлэл байдаг ба сүүлийн 8 жилийн туршид жилд дунджаар 9 тн алт экспортлож байна. Алтны ханш 2012 оноос хойш суларсаар 8.2 хувь буурч, 2015 онд 1 кг алтны экспортын үнэ дунджаар 37,218.4 ам.долларт хүрсэн байна. Дэлхийн зах зээл дээр алтны ханш 2015 оны 12-р сард сүүлийн 5 жилийн хамгийн доод ханш болох 37,390 ам.доллар/кг-т хүрсэн байсан бол эргээд өсөх хандлагад орж, 39,506 ам.доллар/кг болжээ.

Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүн болох зарим эрдсийн нөөц, үйлдвэрлэл, эрэлт болон ханшийн мэдээллээс харахад 2016 онд болон ирэх жилүүдэд эрдсийн эрэлт буурсан хэвээр байх ба үнэ холбоотойгоор Монгол Улсын эрдсийн экспортын нь буурах хандлага үргэлжлэхээр байна. Үүнтэй


орлого үргэлжлэн буурах хандлагатай байна. Тиймээс Монгол Улс эрдсийн экспортыг бага байхаар төсөөлж, бусад боломжит орлогын эх үүсвэрийг бий болгож, эдийн засгийг сайжруулах бодлого баримтлах хэрэгтэй байна.

Монгол Улсын төсөв

Монгол Улсын төсвийн тэнцэл нь улсын эдийн засгийн чухал үзүүлэлт тул төсвийн орлого, зарлагын мэдээллийг сүүлийн 5 жилээр түүвэрлэн графикаар харууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2015 оны эцсээр 5.97 их наяд төгрөг, зардал нь 7.1 их наяд төгрөг, алдагдал нь 1.16 их наяд төгрөг байсан ба алдагдлын хэмжээ өмнөх оныхоос 31 хувиар өссөн байна. Мөн алдагдлын хэмжээ орлогын 19.4 хувьд хүрсэн байна. 2015 оны алдагдлын хэмжээ өсөх гол шалтгаан нь орлого талаас НӨАТ-ын орлого болон нийтлэг татварын бусад орлого буурсантай холбоотой. Зарлага талаас бүх төрлийн зардлууд өссөн ба түүнээс гадна бараа, ажил үйлчилгээний зардал, хүүгийн зардал болон бусад урсгал шилжүүлгийн хэмжээ өссөн байна.


Монгол Улсын нэгдсэн төсөв, сая төг



Эх сурвалж: УСХ

Төсвийн орлогыг бүрдүүлэгч гол орлогууд нь НӨАТ-ын орлого, орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого байна. Нийгмийн даатгалын орлогын төсвийн орлогын бүрдүүлэлтэд эзлэх хувь жил ирэх тусам өсч байгааг төсвийн орлогыг бүрдүүлдэг бусад орлогууд өсөөгүй буюу үйлдвэрлэл болон экспортын хэмжээ өсөөгүйтэй холбож болно. Мөн ирээдүйн хуримтлалыг үүсгэдэг нийгмийн даатгалын орлого нь төсвийн орлого бүрдүүлэгч болсон нь Монгол Улсад нэмүү өртөг үүсгэх бизнесийн орчинг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэх ёстойг харуулж байна.

Төсвийн орлого, түүний гол бүрдүүлэгч, сая төгрөг



Нөгөөтэйгүүр, 2015 онд “Эдийн засгийн ил тод байдлын тухай хууль”-ийг баталж хэрэгжүүлснээр иргэд, ААН-үүд татвараа тодорхой хэмжээгээр ил болгож байгаатай холбоотой 2016 онд орлогын албан татварын хэмжээ өсөх магадлалтай байна. Мөн, 2015 онд батлагдсан НӨАТ-ын хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд 2016 оноос иргэд худалдан авсан бараа үйлчилгээндээ төлж буй НӨАТ-ын 20 хувийг буцаан авах болон сугалаанд оролцох боломжоор хангагдсан явдал нь далд эдийн засгийг тодорхой хэмжээгээр бууруулах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилготой ажээ.

Түүнээс гадна статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас авсан мэдээллээр 2011-2015 онд Монгол Улсын төсөвт нийгмийн даатгалын сангаас нийт 4 их наяд төгрөг төвлөрсөн бөгөөд энэхүү хөрөнгийг

төсөв рүү шилжүүлэх бус зөв бодлого, менежмент хийж, олон улсын жишгээр хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулж, санг өсгөх боломжтой юм.

ДҮГНЭЛТ

Монгол Улсад хөрөнгийн зах зээл үүсч хөгжсөний 25 жилийн ойг 2016 оны 1-р сард тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд энэхүү 25 жилийн хугацаанд шинээр 16 IPO хийгдэж, нийт 107.4 тэрбум төгрөгийн хөрөнгө татагдаж, 2015 оны байдлаар бүртгэлтэй байгаа 235 компанийн нийт зах зээлийн үнэлгээ 1.26 их наяд төгрөгт хүрсэн байна. 2014 оны сүүлээс Засгийн газрын үнэт цаас/бонд Монголын хөрөнгийн биржээр дахин арилжигдаж эхэлсэн нь 2015 оны нийт үнэт цаасны арилжааг 547 тэрбум төгрөгт хүргэсэн ба Засгийн газрын бондын арилжаа нь МХБ-ийн нийт арилжааны 94.3 хувийг эзэлсэн байна. Харин хувьцааны арилжааны хэмжээний хувьд дэлхийн эдийн засгийн зогсонги байдал болон Монгол дах гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан, дотоодын хөрөнгө оруулагчдын худалдан авах чадвар муудсан зэргээс хамааралтайгаар 2012 онд хамгийн дээд цэгээс буурсаар 2015 онд 31 тэрбум төгрөг болж, 2009 оны түвшинтэй ойролцоо болсон байна.

2015 оны 12-р сард МХБ-д бүртгэлтэй компани хоёроор нэмэгдэж, Монголын ипотекийн корпораци холдинг ХК, Монгол шуудан ХК шинээр бүртгүүлсэн ба 2016 он гарсаар Монгол шуудан ХК анхдагч зах зээлийн арилжаагаа амжилттай явуулж, хувьцаа худалдан авах захиалга нь нийлүүлэлтээсээ 2 дахин илүү байсан, улмаар хоёрдогч зах зээл дээр хувьцааны ханш нь 74 хувь хүртэл өссөн нь хөрөнгийн зах зээл дээрх энэ оны анхны эерэг дохио болов. Түүнчлэн, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Айтүүлс ХХК үнэт цаасаа олон нийтэд санал болгох зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос 2016 оны 1-р сард авснаар энэ оны дараагийн IPO тодорхой боллоо.

2015 оны эцсийн байдлаар Монгол Улсын ДНБ дөнгөж 2.3 хувь өсч, чанаргүй зээл 825 тэрбум буюу нийт зээлийн 7 хувийг эзэлсэн таагүй үзүүлэлт гарсан ч инфляци өмнөх онуудынхоос харьцангуй бага буюу 1.9 хувьтай гарлаа. Харин нийт экспортын болон импортын хэмжээ өмнөх оныхоос багассан ч гадаад худалдааны нийт тэнцэл сүүлийн хоёр жил дараалан эерэг дүнтэй гарсан байна. Дэлхийн болон Хятадын эдийн засгийн удаашралтай холбоотойгоор манай экспортын орлогын ихэнх хувийг бүрдүүлэгч гол эрдэс, түүхий эдийн эрэлт багасч, нийлүүлэлт өсч байгаагаас түүхий эдийн үнэ буурч, Монгол Улсын экспортын орлого 2015 онд буурсан бөгөөд 2016 онд үргэлжлэн буурах төлөвтэй байна.

2015 онд Монгол Улсын төсвийн алдагдлын хэмжээ өмнөх оноос 31 хувиар өссөн байна. Мөн, төсвийн орлогын 17.4 хувийг нийгмийн даатгалын орлого бүрдүүлсэн нь төсвийн орлогыг бүрдүүлэгч бусад орлогууд болох НӨАТ-ын орлого, орлогын албан татварын орлого буюу үйлдвэрлэл болон экспортын хэмжээ өсөөгүйтэй холбоотой гэж үзэж байна. Цаашид эрдэс, түүхий эдийн эрэлт хэрэглээ багасч, дагаад үнэ ханш нь буурах төлөвтэй байгаатай холбоотой эрдсийн экспортын орлого буурч, уул уурхайн олборлолтоос болон экспортоос төвлөрөх татварын орлогын бууралт 2016 онд үргэлжлэхээр байна.

Харин Оюу Толгой ХХК-ийн уурхайн олборлолт эхэлснээр зэсийн баяжмалын экспортын хэмжээ 2014-2015 онд өсч, Оюу Толгойн олборлолт эхлэхээс өмнөх үетэй харьцуулахад үнийн дүнгээр 2.5 дахин өссөн байна. Түүнчлэн, 2015 онд Оюу Толгойн далд уурхайн ажлын төлөвлөгөөг баталж, 4.4 тэрбум ам.долларын санхүүжилтийн багцад талууд гарын үсэг зурж баталгаажуулсан нь манай улсын хувьд чухал ач холбогдолтой үйл явдал болж, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ 2016 оноос нэмэгдэх хүлээлтийг үүсгээд байна.